



ГОВСУМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 4/24

Баянтал сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дахь 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 38 дугаар зүйлийн 38.4 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Иргэн Ухаатай овогтой Адъяасүрэн Амарцэцэг нь сумын 2 дугаар багийн нутаг дахь Цагаан азарга хаваржааны зориулалтай 0.07га/700 метр квадрат/, 1 дүгээр багийн нутаг дахь Далхайн дунд хэмээх өвөлжөөний зориулалтай 0.07га/700 метр квадрат/ газруудыг тус тус газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Боржигон овогтой Батнасан Нямсүрэн-д (РД: Н90041017)-д шилжүүлж 2 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу ашиглаж буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг газар эзэмшигч Б.Нямсүрэн-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу авч буй Б.Нямсүрэн-д газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Ц.Загарсүрэн/-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2009 оны А/89 дүгээр захирамжийн 6 дугаар хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АНХБАЯР



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 1125

Баянтал сум

Шуурхай арга хэмжээ авах ажлын хэсэг

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1 Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, Улсын онцгой комиссын 02 дугаар “Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдалд үнэлгээ хийх тухай тогтоол, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд малын гоц халдварт шүлхий өвчин гарсан үед цаг үеийн хойшилуулашгүй шуурхай арга хэмжээг эвч хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Э.Эрхэмбаатар( Засаг даргын орлогч)

Н.Мөнгөнцэцэг (1 дүгээр багийн

Засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ (2дугаар багийн

Засаг дарга)

М.Өмнөрсөрөг (Мал эмнэлгийн мэргэжилтэн)

Х.Пүрэвжаргал (Цагдаагийн хэсгийн

Төлөөлөгч

Нарийн бичгий дарга:

Гишүүд:

2. Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдсон мэдээ, мэдээллийг тухай бүрт танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

3. Малын гоц халдварт шүлхий өвчний үед ажиллахад шаардагдах төсвийн тооцоог гаргаж бэлэн байдлыг ханган ажиллахыг (Ажлын хэсэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

ГАНХБАЯР



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/2

Баянтал сум

**Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх  
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай**


Монгол улсын Засаг захирагаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захирагааны өрөнхий хуулийн 43.1, 43.2, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, 14.1.6, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмнө газраа өмчилж авахаар захирамж гарсан иргэн Боржигон овогтой Энхбаатарын Хүрэлбаатар газрын гудамжны нэрийг Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдүүн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13 дугаар тоогоолоор Сансар-2-209 тоот, газрын хэмжээ 4147м<sup>2</sup>, нэгж талбарын дугаар 4203000359 болж тус тус өөрчлөгдсөн тул өөрчлөн өмчлүүлсүгэй.

2. Өмчилж авсан газраа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусдын өмчлөлд шилжүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тохиолдолд эрх бүхий албан байгууллагаас зөвшөөрөл авч байхыг газар өмчлөгч иргэн (Э.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжны биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2007 оны 68 тоот захирамжийн 15 дугаар хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.





ГОВСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар A/27

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, чутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 46 зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Баянтал сумын Иргэдэд үйлчлэх төвийн тоног төхөөрөмжийн (хаалт, ухаалаг дэлгэц, ширээ сандал, чанга яригч) бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга:

Г.Болормаа (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

С.Оюунтүлхүүр (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Ц.Булган (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг хавсрان гүйцэтгэгч)

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Болормаа)-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 03-р сарын 28-ны өдрийн A/22 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.





БОВСУМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 128

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 46 зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Баянтал сумын 154 дүгээр байрны 3,4,5 дугаар орцны урд талд 24x15 хэмжээтэй, 152,154 дүгээр байрнуудын хажуу талд авто машины 2 хэсэг зогсоол шинээр хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд:

С.Оюунтүлхүүр (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Г.Болормаа (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)


Ц.Булган (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг хавсрان гүйцэтгэгч)

2. Худалдан авах ажиллагааг хуупийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Эрхэмбаатар)-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 03-р сарын 28-ны өдрийн А/23 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.



Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 111

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 46 зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Үнэлгээний хорооны 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Баянтал сумын “Баяр наадмын талбайг засварлах, шинэчлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд:

С.Оюунтулхүүр (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)


Г.Болормаа (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Булган (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг хавсрان гүйцэтгэгч)

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Эрхэмбаатар)-д даалгасугай.



Г.АНХБАЯР

2022 04 25

A/30

ЕБСургуулийн захирал Д.Цэрэннямын  
үндсэн цалинд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны “Төрийн болон орон нутгийн өмчид сургуулийн өмнөх болон өрөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэм хэмжээг тогтоох тухай” А/122 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ерөнхий боловсролын 4-р сургуулийн захирал Даваагийн Цэрэннямын цалингийн зэрэглэлийг ТҮБД-5 шатлалаар 1,126,198 (нэг сая нэг зуун хорин зургаа нэг зуун ерэн найм) төгрөг болгосугай.

2. Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/122 тушаалын 2 дохь хэсэгт заасны дагуу дээрх үндсэн цалинг 5 хувиар нэмэгдүүлж, бусад нэмэгдлийг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу бодож олгохыг 4 дүгээр сургуулийн өрөнхий нягтлан бодогч (Ц.Жаргалмаа)-д зөвшөөрсүгэй.





ОВЬСУМБЭР АЙМАГ  
БАЯНТАI СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/31

Баянтал сум

Б.Энхмэндийг 4-р Цэцэрлэгийн эрхлэгчийн албан  
тушаалаас чөлөөлж, түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 79 дүгээр зүйлийн 79.1, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 43 дугаар зүйлийн 43.1, 57 дугаар зүйлийн 57.2.4, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчид сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэм хэмжээг тогтоох тухай” А/122 тоот тушаал, Авилгатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 05/4857 албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ Нь:

1. Сумын 4-р Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд Батсүхийн Энхмэндийг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлж 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн түр томилсугай

2. Б.Энхмэндийн ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Л.Отгонпүрэв (Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Энхсайхан (Аж ахуйн нярав)

3. Б.Энхмэндийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТҮБД-5 шатлалаар 1,126,198 (нэг сая нэг зуун хорин зургаа нэг зуун ерэн найм) төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл үндсэн цалингийн 25 хувь, бусад нэмэгдлийг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу бодож олгож байхыг Санхүү албаны нягтлан бодогч /Х.Ариунгуд/-д зөвшөөрсүгэй.

4. Б.Энхмэнд ажилдаа хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.





ГОВСУМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 4/32.

Баянтал сум

Соёлын төвийн дарга Х.Энхжаргалын үндсэн  
цалинд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

- Сумын Соёлын төвийн дарга Хатанбаатарын Энхжаргалын цалингийн зэрэглэлийг ТҮСҮ-5 шатлалын 895,945 (Найман зуун ерэн таван мянга есөн зуун дөчин тав) төгрөг болгосугай.
- Х.Энхжаргалд холбогдох бусад нэмэгдлийг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу бодож олгохыг Соёлын төвийн ерөнхий няглан бодогч (Х.Ариунгуяа)-д зөвшөөрсүгэй.





ГӨВЬСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СҮМСИН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1/33

Баянтал сум

Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа  
зохион байгуулах ажлын хэсгийг томилох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.28, 46 дугаар зүйлийн 46.1 дахь заалтууд, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”ын 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулах тухай Сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/21 дүгээр захирамжын дагуу 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр болс хазар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Э.Эрхэмбаатар-(Засаг даргын орлогч)  
Ц. Загарсүрэн – (Газрын даамал)  
Л.Отгонпүрэв – Санхүү албаны дарга)

- Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг журмын дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг тайлгажнахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Эрхэмбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА ГАНХБАЯР